



KHAN BANK

BPN
Business Professionals Network

Монголын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Төлөө



ВРN сан болон ХААН Банкны хамтарсан

Хөгжлийн хөтөлбөр



ВРN Монгол
салбарын
захирал

Маркус Эппер

Бизнесээ хэрхэн хөгжүүлэх вэ?

ВРN сан нь 1999 онд үүсгэн байгуулагдсан ашгийн бус байгууллага бөгөөд Киргиз, Никарагуа, Руанда, Монгол болон Гүрж Улс дах салбар, төлөөлөгчийн газруудаараа дамжуулан нийт 1500 гаруй бизнес эрхлэгчдийг дэмжин, 32000 гаруй ажлын байрыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байгаа билээ. Мөн энэ хугацаанд 1800 гаруй бизнесийн удирдлагын нэн хэрэгцээтэй сургалтуудыг зохион байгуулж, оюуны хөгжил, дэвшлийг бүтээлцэн ажиллаж байна.

ВРN нь 2 жилийн хугацаанд бизнес эрхлэгчдийг тоон болон чанарын өсөлтөд чиглүүлэн ажилладаг бөгөөд хөтөлбөрт хамрагдсанаар Швейцар болон Монгол экспертүүдээс бизнес зөвлөгөө, көүчинг үйлчилгээ авах боломж бүрддэг.

ВРN-ийн бодлогын хүрээнд Монгол Улсын шилдэг санхүүгийн үйлчилгээг үзүүлэгч ХААН Банктай хамтран, өсөх ирээдүйтэй бизнес эрхлэгчдийг дэмжих "Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааг эхлүүлсэн билээ.

"Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хөгжлийн хөтөлбөр"-т хамрагдсанаар бизнес эрхлэгчдэд олон давуу тал, боломжууд үүсэх бөгөөд үүнээс дурдвал:

- ХААН банк болон ВРN-ийн практикт суурилсан бизнесийн удирдлагын сургалтууд болон бизнесийн дүн шинжилгээ;
- ВРN-ийн ганцаарчилсан бизнес көүчинг, зөвлөх үйлчилгээ;
- ХААН банкны хөнгөлөлттэй тоног төхөөрөмжийн зээл;
- Бусад бизнес эрхлэгчидтэй мэдлэг, туршлагаа хуваалцах, Швейцар болон бусад ВРN-ийн салбарын улсууд руу туршлага судлах бизнес аялал хийх;
- ВРN-ийн бизнес эрхлэгчдийн нийгэмлэгээс зохион байгуулагддаг бусад арга хэмжээнүүдэд оролцох

Компаниа цааш нь хөгжүүлэх, сайн бизнес модель боловсруулж, суралцах хүсэлтэй бизнес эрхлэгчид та бүхэнтэй бид хамтран ажиллахдаа баяртай байх болно.

ВРN Монгол салбарын захирал

Маркус Эппер

ХААН Банк BPN сантай хамтарсан жижиг дунд үйлдвэрийг дэмжих

Тоног төхөөрөмжийн

зээл олгож эхэллээ.

ХААН Банкны Жижиг Дунд Бизнесийн Газар

Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг бий болгох, түүнийг нэмэгдүүлэх зорилгоор BPN сантай хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд ХААН Банк нь тус сангийн эх үүсвэрээр бизнес эрхлэгчдэд энэхүү зээлийг гаргаж байна.

Зээлийн зориулалт: Үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөн техник технологи шинэчилж тоног төхөөрөмж худалдан авах

Зээлийн хүү: Жилийн 8.0% /найман хувь/

Зээл хүсэгчид тавигдах шаардлага:

- ХААН Банк болон BPN сангийн хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийн оролцогч байх;
- Монгол улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
- Сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд тогтвортой бизнес эрхэлж байгаа бөгөөд цаашид эрхлэх аж ахуйн нэгж байх;
- Банкны шалгуур болох санхүүгийн харьцаануудыг бүрэн хангасан байх;
- Банкны шаардлага хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх;
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;
- Банк болон бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл нь муу ангилалд ангилагдсан түүхгүй байх;
- Тухайн үед мөрдөгдөж буй ХААН Банкны хөрөнгө оруулалтын зээлийн бүтээгдэхүүний нөхцөл, шаардлагыг хангасан байх.



Жижиг Дунд
Бизнесийн
Газрын
Мэргэжилтэн

Э.Оюунцэцэг



ВРН Сангийн төлөөлөгчийн газар болон ХААН Банкны хамтарсан жижиг дунд үйлдвэрлэлийн Хөгжлийн хөтөлбөрийн талаар ВРН-ийн бизнес көүч Х.Ундармаатай ярилцлаа.

ВРН болон ХААН Банктай хамтарсан хөтөлбөр хэрэгжиж эхэлж байна. Энэ хөтөлбөрийн талаар мэдээлэл өгнө үү.

Юуны өмнө ВРН байгууллагын онцлогийг танилцуулья. Бид 2012 оноос хойш Швейцарын ВРН Сангийн санхүүжилттэй жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэн, улмаар тус сангийн Төлөөлөгчийн газар гэсэн статустай, үйл ажиллагаагаа тогтмол явуулж ирсэн. Швейцарын үйлдвэрлэгчдийн баримталж ажилладаг туршлага, мэдлэгийг Монголын бизнес эрхлэгчдэд сургалтууд болон зөвлөх үйлчилгээгээр хөрөнгө оруулалт хийдэг гэж ойлгож болно. Үүнээс гадна бизнес эрхлэгчдэд өөр хоорондоо нетворкинг хийх, Швейцарын туршлага судлах бизнес аялалд хамрагдах зэрэг бусад олон боломжууд гарч ирдэг.

Манай хөтөлбөрт тоног төхөөрөмжийн санхүүжилт гэсэн үндсэн чиглэл байдаг. Энэ чиглэлийн дагуу Монгол Улсын нийгэм, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах, цаашид хөгжих боломжтой, тогтвортой, хариуцлагатай жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, чадавхжуулах гэсэн зорилготойгоор ХААН банктай урт хугацаанд хамтарч ажиллах санамж бичиг байгуулсан. Гэрээг эцэслэн байгуулахад багагүй хугацаа зарцуулсан бөгөөд гэрээний дагуу тоног төхөөрөмжийн зээлийн санхүүжилт орж ирснээр хөтөлбөр маань одоо хэрэгжиж байна.

Уг хөтөлбөр зээлийн бүтээгдэхүүнээс гадна ямар онцлог үйл ажиллагаа явуулах вэ?

ХААН Банкны Жижиг Дунд Бизнес Эрхлэгчдийг Дэмжих Төвтэй хамтарсан хөтөлбөрийн гол онцлог нь бизнес эрхлэгчид зөвхөн тоног төхөөрөмжийн зээл бус компанийн менежментийн ур чадвар, мэдлэгээ сайжруулах цогц мэдлэгийг, нарийн төлөвлөгөө, хуваарийн дагуу олж авах юм. Дахин хэлэхэд бизнес эрхлэгчид тоног төхөөрөмжийн зээл авна, давхар үнэ төлбөргүйгээр өөрийгөө болон компаниа хөгжүүлэх том боломж гэсэн үг.

Санхүүжилт хэрэгцээтэй олон бизнес эрхлэгч байгаа. Зээл авахад тавигдах тодорхой шаардлага байгаа юу? Ямар бизнес эрхлэгчид санхүүжилтийг авах боломжтой вэ?

ВРН-ийн хөтөлбөрийн оролцогчид болон хамтарсан дэмжих хөтөлбөрт хамрагдаж байгаа бизнес эрхлэгчид санхүүжилтийг авах боломжтой. Мэдээж банкны зүгээс зээл авахад тавигддаг тодорхой шаардлага байна. Энэ зээлийн бүтээгдэхүүний хүү нь бусад бизнесийн зээлтэй харьцуулахад харьцангуй бага буюу жилийн 8% байх ба 36 сар хүртэл хугацаатай байх юм. Бизнесээ тогтворжуулах, үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, өргөжүүлэх энэ хугацаанд бид бизнес эрхлэгчдэд бизнесийн үнэ төлбөргүй көучинг үйлчилгээгээр дэмжлэг үзүүлэн ажиллана.

Зээлийн бүтээгдэхүүний эрэлт өндөр байгаа энэ үед бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байгаадаа бид баяртай байна.

Ярилцсанд баярлалаа. Б. Мөнхзүл



ВРН-ийн
Бизнес көүч:

Х.Ундармаа



Сургалтын талаарх мэдээлэл:



Бизнесийн удирдлага

2021 оны 10-р сарын 13-15 /3 өдөр/
Удирдагч: Маркус Эппер



Цагийн менежмент

2021 оны 10-р сарын 26-27 /2 өдөр/
Удирдагч: Маркус Эппер



Маркетинг

2021 оны 11-р сарын 04-06 /3 өдөр/
Удирдагч: Маркус Эппер



Хамт олноо удирдах

2021 оны 11-р сарын 23-25 /3 өдөр/
Удирдагч: Маркус Эппер



Санхүүгийн менежмент

2021 оны 12-р сарын 09-11 /3 өдөр/
Удирдагч: Маркус Эппер



БPN Монгол, СБД, 8-р
хороо, Оюутны 33,
"ТАНАН" төв, 404 тоот

70113309, 77113309
info@bpn.mn
www.bpn.mn

 BpnMongolia

 BPN.Mongol

